

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“1 дүгээр зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

“5.1.8.Малын генетик нөөцийн тухай хуульд заасны дагуу мал бүртгэлийн ажил зохион байгуулах.

2/10 дугаар зүйл. Мал эмнэлгийн гэрчилгээ

“10.1.Малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдзах зээлд худалдах, бусдад шилжүүлэх зорилгоор ялган тэмдэглэсэн мал, нийтийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн мах, малын гаралтай түүхий эдэд сум, дүүргийн мал, эмнэлгийн тасаг мал, эмнэлгийн гэрчилгээ, хувийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн маханд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тодорхойлолт олгоно.

10.2.Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

3/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“12.2.Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлийг Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.9-д заасны дагуу баталсан журмаар зохицуулна.”

4/13 дугаар зүйлийн 1 дэх заалт:

“13.1.Отор нүүдлийн зорилгоор сум, дүүргийн нутаг дэвсгэрээр дамжиж өнгөрөх туврын замын чиглэлийг тухайн сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэлийг Засгийн газар тус тус батална.”

2 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.1.4 дэх заалт, 16.5.4 дэх заалтын “мал, мах бэлтгэлийн гарал үүслийн гэрчилгээ” гэснийг “мал эмнэлгийн гэрчилгээ” гэж, 11.1 дэх хэсгийн “Нутгийн захиргааны байгууллага” гэснийг “сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг” гэж, 11.2 дахь хэсгийн “нутгийн захиргааны байгууллагад” гэснийг “сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт” гэж, 12.1 дэх хэсгийн “тухайн малчин малдаа” гэснийг “Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.5-д заасны дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.2 дахь хэсэг, 11.4 дэх хэсгийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.”

ГАРЫН ҮСЭГ